



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГAA-2024/07/НА-СТА-ТТЗ

Цахим  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Алтай хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа  
Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
хуудас: Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Цэрэнханд  
Утас: 99086371 Цахим хаяг: [tserenkhandd@audit.gov.mn](mailto:tserenkhandd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 03. 26 № 143

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Есөнбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 1,850.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн, малын тоо, толгойн албан татварыг 4.6 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.8 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 0.6 сая төгрөгөөр, малын тоо, толгойн албан татварын орлого 29.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй, сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон зэрэг нийт 1,892.0 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1,2,5 дахь заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0702700458

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 дугаар тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг хүргүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны зардлын нийт гүйцэтгэл өмнөх оноос 2,420.9 сая төгрөг буюу 25.0 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 8 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 178 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 96.8 хувийн биелэлттэй гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 89.2 хувиар дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах ~~хэрэглэгчдийн өдийн~~ засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА



**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**/мянган төгрөг/**

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,445,551.0	2,609,905.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,974,158.6	11,570,670.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>15,419,709.6</b>	<b>14,180,576.0</b>
Нийт өр төлбөрийн дүн	111,583.5	291,261.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,308,126.1	13,889,314.4
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>15,419,709.6</b>	<b>14,180,576.0</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	18,175,380.5	18,120,505.8
Үйл ажиллагааны зардлын дүн	15,125,017.6	13,831,749.6
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>3,050,362.9</b>	<b>4,288,756.3</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	30,405,916.1	2,118,377.8
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(27,355,553.2)</b>	<b>2,170,378.4</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,415,246.0	16,059,692.8
Тайлант оны үр дүн	(27,355,553.2)	2,170,378.4
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>16,059,692.8</b>	<b>13,889,314.4</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	15,691,297.4	13,249,239.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	14,053,477.2	10,525,373.4
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>1,637,820.1</b>	<b>2,723,865.9</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(1,380,403.0)</b>	<b>(2,552,902.7)</b>
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>(340,000.0)</b>	<b>(200,000.0)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(82,582.9)</b>	<b>(29,036.8)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	800,808.1	718,225.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	718,225.2	689,188.5

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 8,026,495.3 мянган төгрөгийн 9 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 1,892,007.5 мянган төгрөгийн 60 зөрчил илрүүлснээс, 59,245.2 мянган төгрөгийн 19 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,832,762.3 мянган төгрөгийн 36 зөрчил арилгах албан шаардлага, 2 зөвлөмж, 8 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 1,892,007.5 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 198,700.0 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

**5.1.1 Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага бүрэн 23 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал, 3 тусгай сан, 2 ААТҮГ, 1 төрийн сангийн санхүүгийн тайлан нэгтгэснээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 20 байгууллага, 3 тусгай сан түүвэрт хамруулсан

Аудитаар Жаргалан-Алтай, Энх-Алтай ӨЭМТ-ийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт, сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт, Марал-Алтай ӨЭМТ-ийн санхүүгийн тайланд “Татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна.

### **5.1.2 Түүвэрт хамрагдсан Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар ХХС-гийн санхүүгийн тайланд 31,851.5 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, авлагын гэрээт хугацаанд төлүүлээгүй 11,264.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

### **5.1.3 Дүгнэлт өгсөн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар 1,934,786.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 18,571.0 мянган төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоож, 1,916,215.0 мянган төгрөгийн 38 зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн албан шаардлага, 8 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

### **5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нэгтгэсэн тайланд 7,533,402.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулсан.

Аудитаар нийт 41,040.6 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 29,409.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,6310.3 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж байна.

#### **5.1 Төлбөрийн акт**

1.Малын тоо, толгойн албан татварын орлого 29,409.3 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй малын хөлийн албан татварыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

#### **5.2 Албан шаардлага**

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тулган баталгаажуулахад малын хөлийн албан татвар 4,590.6 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,851.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 598.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэлт:** Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллан, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудад залруулагдаагүй 31,851.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч 29,835.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,916,215.0 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 8 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. ЗДТГ, ИТХ-д 4,591.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Есөнбулаг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 3 дугаар тогтоолын 2 дахь заалттай нийцэхгүй байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Есөнбулаг сумын Төсвийн	4	7,994,643.7			4	7,994,643.7	4	7,994,643.7	-	-	-	-

төвлөрүүлэн захирагч												
Есөнбулаг сумын ХХС	5	31,851.5			5	31,851.5	5	31,851.5	-	-	-	-
Дүн	9	8,026,495.3	-	-	9	8,026,495.3	9	8,026,495.3	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын ТТЗ	4	41,040.6	1	29,409.3	3	11,631.3	-	-	-	-	-	-
Есөнбулаг сумын ЗДТГ	23	1,487,560.1	6	9,309.4	17	1,478,250.7	-	-	4	-	-	-
Есөнбулаг сумын ИТХ	14	208,892.5	2	1,266.4	11	207,625.9	1	-	1	-	-	-
Есөнбулаг сумын ХХС	1	11,264.6	1	11,264.6						-	-	-
Есөнбулаг сумын ОНХС										-	-	-
Есөнбулаг сумын БХНСС										-	-	-
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	5	54,646.5	1	1,411.6	3	53,234.9	1					
Энх-Алтай ӨЭМТ												
Жаргалан-Алтай ӨЭМТ	1	900.0			1	900.0	-	-	-			
Марал-Алтай ӨЭМТ	11	87,703.2	7	6,583.7	1	81,119.5	-	-	3			
Дүн	59	1,892,007.5	18	59,245.2	36	1,832,762.3	2	-	8	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Есөнбулаг сумын ЗДТГ	2	31,855.4			2	31,855.4	-	-
Есөнбулаг сумын ХХС	2	3,725.0			2	3,725.0		
Алтай хотын тохижилт үйлчилгээний газар								
Дүн	1	59,503.6			1	59,503.6	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтийг	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1	-	-	-	1	-	-
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>